

~ Японы талаар илүү сайн мэдэж авцгаая ~

2023 оны 10 дугаар сар

НАМРЫН ДУГААР

Сэдэв

Мангагаар дамжуулан мэдэж авцгаая. Улирлын арга хэмжээ “Японы Халовин”

◇ Ур чадварын дадлагажигчаас асуулаа! Японы амьдралын ийм, тийм юмны талаар

◇ Мэдэх үү? Японы “Гоймон”-гийн соёлын талаар

こくごのもり/kokugo no mori/“Өгүүлбэр бүтээцгээе”

Tìm hiểu sự kiện và thời tiết qua truyện tranh manga

— Lễ hội Halloween ở Nhật Bản —



Бүдээрээ Халовиныг сайхан өнгөрөөцгөөе!

Уул нь гадаадын баяр байсан Халовин нь жилийн энэ үед Японд ч алдартай. Хөөрхөн сүнс болон гүнж, дуртай анимэгийнхээ алдартай дүрийн дүрд хувирах хувцас өмсөөд, партид орж хөгжилддөг. Та бүхэн ч гэсэн дүрмийг нь баримтлаад, Халовины баяраар хөгжилдөж үзээрэй.

“とも/Томо” нь, Японд амьдрахад хэрэг болох мэдээлэл, Япон хэл сурахад хэрэг болох зүйлс зэргийг, дуудлагыг нь хадсан Япон хэл болон гадаадын 9 орны хэл (Вьетнам, Хятад, Филиппин, Индонези, Тайланд, Камбодж, Мьянмар, Монгол, Англи) дээр гаргадаг. Япон хэл дээрх хувилбарыг товхимол хэлбэрээр хүргэдэг ба гадаад хэл дээрх хувилбарыг JITCO-гийн цахим хуудаснаас ухаалаг утас зэргийг ашиглан, PDF хэлбэрээр харах боломжтой. Та бүхэнд орж харахыг санал болгож байна.
(<https://www.jitco.or.jp/ja/tomo/>)



Ур чадварын дадлагажигчаас асуулаа! Японы амьдралын ийм, тийм юмны талаар

Ур чадварын дадлагажигч бусад хүмүүс яаж амьдарч байна вэ?

Киото мужид амьдардаг Ур чадварын дадлагажигч, THIDA LWIN / ТИДА ЛВИН сан (25 настай)-тай
ярилцлаа.

Нэр: THIDA LWIN / ТИДА ЛВИН

Төрсөн нутаг: Мьянмар

Дадлагын агуулга: Асаргаа

Японд ирээд: 3 жил

Өөрийн танилцуулга: Хөгжилтэй зантай
бөгөөд эргэн тойрны хүмүүсээ байнга
хөгжөөж явдаг.



監理団体：大阪人材開発事業協同組合
実習先：医療法人社団 医聖会 学研都市病院

◆ Японд ирэхэд юу нөлөөлсөн бэ? Мөн, Японд ирэхийн өмнөх болон ирсний дараах Японы тухай төсөөлөлд тань өөрчлөлт гарсан уу?

Японд ирсэн шалтгаан бол, мөнгө хуримтлуулах, бас Японы
анимэд маш дуртай болохоор. Японд ирэхийн өмнө, Японы
талаар телевизээр үздэг байсан үед, хөл хөдөлгөөн, хүн
ихтэй, бүгдээрээ завгүй хичээж байдаг гэсэн төсөөлөлтэй
байсан. Миний амьдарч байгаа нутаг хүн цөөтэй, нам гүм,
хүмүүс нь тус тусын ажилдаа хичээнгүйлэн чармайдаг.

◆ Японд амьдраад гайхсан зүйл, хэцүү зүйл юу вэ?

Хаашаа ч харсан баахан ханз, юу гэж бичсэн байгааг
ойлгодоггүй байсан. Одоо ч хэцүү боловч, ойлгохгүй
юмаа хүнээс асуух, ухаалаг утсаараа хайлт хийх, ном
унших гэх мэтээр суралцаж байна. Өөр нэг юм бол,
Мьянмар хоол хиймээр санагдсан үед, Мьянмар
хүнсний материал, амтлагч хайж олоход хүндрэлтэй
байсан. Одоо бол интернетээр Мьянмарын дэлгүүрээс
хүргэлтээр худалдан авч, хоол хийдэг.

◆ Хамгийн дуртай Япон хоол тань юу вэ? Эсрэгээрээ, яасан ч идэж чаддаггүй юм байгаа юу? Мөн идэж чаддаг болсон идэх юм байгаа юу?

Маш дуртай идэх юм бол осүши (агшаасан
цагаан будааг уксуураар амталж, дээр нь түүхий
загас тавьсан хоол), окономи-яки (байцаа,
гахайн мах, ногоон сонгино г.м төрөл бүрийн
материалыг шингэн гурилтай хольж, гамбир
хэлбэртэйгээр шарсан хоол). Эсрэгээрээ, идэж
чадахгүй юм бол натто (даршилсан шар
буурцаг). Бага зэрэг идэж чаддаг болсон нь
тунхуу. Тунхууг осүшитэй хамт идэхэд ч
дуртай болсон.



◆ Японд ирээд, хамгийн их сэтгэл хөдөлсөн зүйл юу вэ?

Японд ирээд хамгийн их сэтгэл
хөдөлсөн юм бол цас. Мьянмарт
өвөл болдог боловч миний
амьдарч байсан хотод цас
ордоггүй.

◆ Япон хэлийг яаж сурч байна вэ?

Өдөр бүр ханз бичиж, ном уншдаг. Японы
анимэ, цуврал кино үзэж, үг хэллэгийг
яаж хэрэглэх талаар ч ойлгодог болж
ирсэн. Сонсголын дасгалд ч эерэг үр
дүнтэй байдаг.

◆ Ирээдүйн мөрөөдөл тань юу вэ?

Миний мөрөөдөл бол
Асрагчийн үнэмлэх
аваад, Японд удаан
ажиллах явдал.

◆ Амралтын өдрөө юу хийж өнгөрөөдөг вэ? Хүч сэлбэх ямар арга хэрэглэдэг вэ?

Амралтын өдрөө худалдан авалт
хийх, хоол хийх, өрөөгөө цэвэрлэх
г.м-ээр өнгөрөөдөг. Хааяа дугуйгаар
цэцэрлэгт хүрээлэн явах нь ч бий.

◆ Ур чадварын дадлагажигч дүү нартаа нэг үг хэлнэ үү!

文化を建てるばかりで 国を事も 悩む 喜ぶ ありがとう 楽しい
事も 出来る 言葉のために 日本語を 勉強に 頑張るよ



JITCO-гоос, Японд амьдардаг гадаад хүмүүст зориулсан оршин суух хөтөч ном “Япон дахь амьдралын
танилцуулга”-ыг 13 орны хэлээр гарган, худалдаалж байна. JITCO сурах бичгийн онлайн дэлгүүрт зарим
хэсгийг нь уншиж үзэх боломжтой болохоор, сайтаар ороод үзээрэй гэж урьж байна.

<https://onlineshop.jitco.or.jp/shopdetail/000000000233>



Мэдэх үү? Японы “Гоймон”-гийн соёлын талаар

Дэлхий нийтэд янз бүрийн “гоймон” байдаг. Өөрийн орондоо гоймонтой хоолонд дасал болсон байсан хүн ч олон байгаа биз ээ. Японд ч хүмүүс гоймонтой хоолонд дуртай байдаг ба гадуур хооллохоос гадна гэртээ хийж иддэг тохиолдол ч байна. Японд түгээмэл байдаг гоймонтой хоол гэвэл, “うどん/ udon / үдон (бүдүүн гоймонтой халуун шөл)”, “そば/ soba / соба (гурвалжин будааны гоймон)”, “ラーメン/ ramen / раамэн” зэрэг санаанд орох ба эдгээрийн дотроо бас нутаг нутгаараа шөлний амт болон хачир, мөн гоймонгийн хатуулаг болон нарийн, бүдүүнээрээ ялгаатай, янз бүр байдаг. Хүйтэн өвөлд халуун шөлтэй “味噌ラーメン/ miso ramen / мисо раамэн (жангаар амталсан раамэн)” болон “鍋焼きうどん/ nabe yaki udon / набэ яки үдон (бүдүүн гоймонтой халуун шөл)” зэргийг идэж дулаацан, халууны улмаас хоолны дуршил буурдаг зунд, хөнгөн чанарын “ざるそば/ zaru soba / зару соба (гурвалжин будааны гоймонг чанаж хөргөөд, хүйтэн соусанд дүрж иддэг хоол)” болон “そうめん/ somen / соомэн (нарийн гоймон)” зэрэг хүйтнээр иддэг гоймонд дуртай байдаг. Мөн нутаг нутгаараа, янз янзын тухайн нутгийн гоймонгууд “Төрсөн нутгийн амт” хэмээгдэн дасал болсон байдаг.

Япончуудын дотор гоймон идэхдээ, “ずるずる/ zuru zuru / зүрү зүрү” гэж дуу гарган, сорж иддэг хүн их байдаг. Анх удаа энэ дууг сонсохдоо, та гайхсан байж магадгүй юм. Дуу гаргаж хоол идэх нь ёс зүйн зөрчилтэй гэж үздэг улс орон болон соёл олон байдаг байхад, яагаад Японд гоймонг идэхдээ дуу

гарган, сорж иддэг болсон юм бол? Хэд хэдэн таамаг байдгийн нэг нь, гоймонг сорохдоо хамт агаар сорсноор, аман дотор үнэр нь тархаж, амт нь улам тодордог гэж яригддаг. Ялангуяа “そば / soba / соба (гурвалжин будааны гоймон)” идэх үед илүү мэдрэгдэх болов уу. Мөн гоймон нь цаг хугацаа өнгөрөхөөр сунаж, хатуулгаа алддаг. Гоймонг түргэн бөгөөд амтлан идэхийн тулд сорж иддэг болсон ч гэж яригддаг.

Та бүхэн бас өөрийн амьдардаг нутагтаа тухайн нутгийнхаа гоймонг хайж олоод, идэж үзээрэй. Тэр үедээ гоймон сорж идэх аргаар идэхийг оролдож үзэхийг санал болгож байна.



Кокуго-но-мори

Энэ нь Япон хэлний үг хэллэг, ханз болон эдгээрийн хэрэглэх аргын талаар суралцахад зориулсан сурах бичиг болно. Зугаатайгаар хариуг нь бодож олцгооё. (Хариу нь дараагийн хуудсанд байгаа.)



Ур чадварын дадлагажигч, Энэ сарын зураг



Асрамжийн газар ажилладаг Индонезийн Ур чадварын дадлагажигч нар анх удаа Диснейланд яваад ирлээ. Явсан өдөр бороотой байсан боловч хөгжилтэй цагийг өнгөрөөж чадсан. Үүнийгээ урам болгож, ажилдаа шамдана даа!

※2023年6月投稿 (ケアサポート瑞穂)

Ур чадварын дадлагажигчийн хүлээн авагч байгууллагуудаас JITCO-гийн цахим хуудсанд ирүүлсэн “Ур чадварын дадлагын Days”-ээс нэг зургийг сонгон нийтэлж байна. “Ур чадварын дадлагын Days” хуудас болон зураг ирүүлэх удирдамжийг эндээс харна уу.

(<https://www.jitco.or.jp/ja/days/>)



JITCO нь “Ур чадварын дадлагажигч гадаад иргэд, сургалтанд хамрагдагчдын Япон хэлний зохион бичлэгийн 31-р уралдаан”-ыг зохион байгуулж, шагналын эздийг JITCO-гийн цахим хуудсаар зарласан. Шилдэг бүтээлийн цомгийг ч цахим хуудсандаа жич байршуулна. Та бүхнийг сонирхон харахыг урьж байна.



Зөвлөгөө өгөх цонхны танилцуулга

[Асуудал тулгарсан үед ...?](https://www.otit.go.jp/notebook/) (<https://www.otit.go.jp/notebook/>)

ОТИТ (Гадаад иргэдийн ур чадварын дадлагын байгууллага)-ын “Асуудал тулгарсан үед ур чадварын дадлагажигчдын эх хэл дээр нь зөвлөгөө өгөх цонх” болон бүс нутгийн зөвлөгөө өгөх цонх, гамшгаас сэргийлэх мэдээлэл, хэрэг болох аппликейшн “げんばの にほんご /Гэнба но нихонго/Ажлын байранд хэрэглэх Япон хэл”, “Ур чадварын дадлагажигчдад зориулсан гарын авлага” зэргийг ашиглах боломжтой.



◆ここくこたえの例

強い風がぼうしをふきとばした。

夜中、やねの上で、ねがなくていた。

ぼくは、弟のたん生日に、おり紙の金メダルをあげた。

文は、主語と述語で成り立ちます。まず、主語と述語を確かめましょう。

(1)は、「ふきとばした」のは「風」です。

(2)の「夜中」には、「に」をつけてもつけなくてもいいでしょう。「夜中」が、時を表しているからです。

(3)では、「誕生日」は、ぼく・弟のどちらか分かりません。決め手は、「あげた」です。「弟がぼくにあげた」とは言いません。

Өгүүлбэр нь субъект болон предикатаас бүтдэг. Юуны өмнө, субъект болон предикатыг магадалцгаая. (1)-ийн тухайд, “ふきとばした / fukitobashita / фүкитобаши́та (хийсгэсэн)” нь “風 / kaze / казэ (салхи)”, “ふきとばされた / fukitobasareta / фүкитобасаре́та (хийссэн)” нь “ぼうし / boshi / бооши (малгай)” юм. (2)-ын “夜中 / yonaka / ёнака (шөнө дунд)”-д “に / ni / ни (-ад)” залгасан ч, залгахгүй байсан ч болох болов уу. “夜中 / yonaka / ёнака (шөнө дунд)” нь цагийг илэрхийлж байгаа учраас юм. (3)-ын “誕生日 / tanjubi / танжооби (төрсөн өдөр)” нь “ぼく / boku / боку (би), 弟 / ototo / отоото (эрэгтэй дүү)” хоёрын алийг нь зааж байгааг мэдэхгүй. Түлхүүр үг нь, “あげた / ageta / агэ́та (өгсөн)”. “弟がぼくにあげた / ototo ga boku ni ageta / отоото га боку ни агэ́та (дүү надад өгсөн)” гэж ярьдаггүй.

とも

2023年10月 秋季号

2023年10月1日発行

発行

公益財団法人 国際人材協力機構 (JITCO)

総務部広報室

〒108-0023

東京都港区芝浦2-11-5

五十嵐ビルディング

電話

03-4306-1166 (ダイヤルイン)

JITCO ホームページ

<https://www.jitco.or.jp/>